



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2012 оны 07-276/392 тоот дүгнэлтээр зориулалтаар ашиглах боломжгүй нь тогтоогдсон, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулинд шинээр барилга барих санхүүжилтийн эх үүсвэр нь батлагдсан байх тул Хууль сахиулахын их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 1,037,742,200.00 (нэг тэрбум гучин долоон сая долоон зуун дөчин хоёр мянга хоёр зуун) төгрөгийн балансын үнэ, 705,129,108.59 (долоон зуун таван сая нэг зуун хорин есөн мянга нэг зуун найман төгрөг тавин есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Хууль сахиулахын их сургуулийн захирал, хошууч генерал Ш.Лхачинжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, буулгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж буулгах, газар /чөлөөлөгдөх талбай/-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000181

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн
9/4 дугаар тогтооллын хавсралт



ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГӨЛТӨЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байрлал	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Спорт заал (Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Хилчний гудамж, өөрийн байранд)	1978	530,252,800.00	359,246,271.78	171,006,528.22
2	Гал зуух (цэргийн, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Хилчний гудамж, өөрийн байранд)	1978	479,092,600.00	324,585,236.81	154,507,363.19
3	Цонх (вакум)	2007	28,396,800.00	21,297,600.00	7,099,200.00
	Нийт дүн		1,037,742,200.00 (нэг тэрбум гучин долоон сая долоон зуун дөчин хоёр мянга хоёр зуун төгрөг)	705,129,108.59 (долоон зуун таван сая нэг зуун хорин есөн мянга нэг зуун найман төгрөг тавин есөн мөнгө)	332,613,091.41 (гурван зуун гучин хоёр сая зургаан зуун арван гурван мянга ерэн нэгэн төгрөг дөчин нэгэн мөнгө)